

АВТОТЭЭВРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ ТӨҮГ-ЫН
ЗАХИРАЛ



БАТЛАВ.
Т. ДЭЛГЭРНАРАН

“АВТОТЭЭВРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ” ТӨҮГ-ЫН
“АВТОТЭЭВРИЙН ТЭРГҮҮНИЙ АЖИЛТАН”
ЦОЛ ТЭМДГИЙН ЗАГВАР ЗОХИОХ ШАГНАЛТ
УРАЛДААНЫ УДИРДАМЖ

2016.11.22

Улаанбаатар хот

1. Зорилго:

Засгийн газрын 1997 оны 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Засгийн газрын салбарын тэргүүний ажилтан буюу хүндэт тэмдгийн төрөл болон тэдгээрийг олгох эрх бүхий албан тушаалтны жагсаалт”-д Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн тогтоолоор 48 дахь заалт “Автомобильн тэргүүний ажилтан” цол тэмдэг нэмсэнтэй холбогдуулан цол тэмдгийн загвар гаргах уралдаан зарлах.

2. Хамрах хүрээ:

Цол тэмдгийн эх бэлтгэж, загвар гаргаж, үйлдвэрлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж байгууллагууд оролцох боломжтой.

3. Ерөнхий шаардлага:

- ▣ Загвар нь автоматтэврийн салбарын чиг үүрэг, үйл ажиллагааны онцлогийг бэлэгдсэн дүрслэлтэй.
- ▣ Хэмжээ: Урт 50мм, өргөн 30мм, зузаан 2,5мм харьцаатай.
- ▣ АТҮТ ТӨҮГ-ын логоны үндсэн өнгийг /шар, цэнхэр/ багтаасан байх.
- ▣ Цол тэмдгийн загварыг, зургийн хамт ирүүлэх. /А4 –ийн цаасан дээр тусгах/
- ▣ Загварын өгүүлэмжийн тайлбар, өнгөний код, орц хийцийн санал, шаардагдах зардлын тооцоог гаргасан байна.
- ▣ Бэлгэдлийг зураг, графикаар дүрслэхээс гадна бичвэр оролцуулж болно.
- ▣ Загвар дизайны өвөрмөц шийдэлтэй, дахин давтагдашгүй хийцтэй байх.

4. Шагнал урамшуулал: 1,0 сая төгрөг /Нэг сая төгрөг/

5. Мэдээллийг олон нийтэд хүргэх хэлбэр:

- ▣ Өдөр тутмын сонин хэвлэл
- ▣ Сошиал медиа хэлбэрээр

6. Уралдаанд оролцох материалыг хүлээн авах хугацаа:

Уралдаанд ирүүлэх бүтээлийг 2016 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 17:00 цаг хүртэл хүлээн авна.

7. Материал хүлээн авах хаяг:

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 2-р хороо, Чингисийн өргөн чөлөө, Автотээврийн үндэсний төв ТӨҮГ-ын төв байр, Захиргаа, сургалт, хүний нөөцийн хэлтэс, ХМОНХМэргэжилтэн Ц.Мягмарсүрэн, Холбогдох утасны дугаар 86063600

8. Уралдааныг дүгнэх:

Уралдаанд ирүүлсэн бүтээлүүдийг томилогдсон ажлын хэсэг тавигдсан шаардлагын дагуу дүгнэж 2016 оны 12 дугаар сарын 01-ний өдөр хуралдаж сонгон шалгаруулна.

Уралдааныг дүгнэх ажлын хэсгийн бүрэлдэхүүнд:

Дэд захирал


ЗСХНХ-ийн Дарга

СЭЗХ-ийн Дарга

ЗСХНХ-ийн Ахлах мэргэжилтэн

МТСХХ-ийн Мэргэжилтэн

ЗСХНХ-ийн Мэргэжилтэн



Х.Баярхүү

Т.Мөнгөн

Я.Оюунсүрэн

Ц.Хонгорзул

Д.Өсөхбаяр

Ц.Мягмарсүрэн

Удирдамж боловсруулсан:

ТМХ-ийн Мэргэжилтэн



Д.Пүрэвдагва